

HEALTHY BIRTH DAY, INC.

(мөн “COUNT THE KICKS” гэж нэрлэдэг)

АШИГЛАХ НӨХЦӨЛ

2018 оны 7 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Оршил

“Healthy Birth Day 501(c)(3)” ашгийн бус байгууллагын эрхэм зорилго бол “Count the Kicks” олон нийтийн эрүүл мэндийн ойлголтыг нэмэгдүүлэх аяны хүрээнд амьгүй төрөлтийн тоог эрс бууруулах явдал юм. “Count the Kicks” нь эцэг эх болж буй хосуудад жирэмсний сүүлийн гурван сард ургийн хөдөлгөөнд хяналт тавих аргачлал, ач холбогдлыг зааж сургадаг. Жирэмсэн эхчүүд өөрийн үрийн хөдөлгөөний хэв маягийг таньж мэдсэнээр, улмаар аливаа өөрчлөлт мэдрэгдмэгц эмчдээ мэдэгдэх хэрэгтэйг ойлгосноор өөрийн үрийг аврах боломжтой. Дараах Ашиглах нөхцөл нь таны манай “Count the Kicks” хэрэглүүрийг ашиглах харилцааг удирдан зохицуулна.

Ашиглах нөхцөлийг зөвшөөрөх

Эдгээр нөхцөлийг та болон тус компани, түүний харьяа болон салбар байгууллагууд (“Компани” эсвэл “бид” эсвэл “бид нар” гэх) харилцан зөвшөөрч байна. Дараах заалтууд болон нөхцөлүүд нь тэдгээрт илэрхий дурдсан лавлагаа баримт бичгүүдийн хамтаар (нийтэд нь, эдгээр “Ашиглах нөхцөл” гэх) таны манай “Count the Kicks” хэрэглүүрт (манай “Апп”) хандах, түүнчлэн “Count the Kicks” Апп эсвэл www.countthekicks.org цахим хуудаснаа эсвэл тэдгээрээр дамжуулан санал болгож буй аливаа контент, функц, болон үйлчилгээг авах харилцааг зохицуулна.

Та Апп-ыг хэрэглэж эхлэхийн өмнө Ашиглах нөхцөлийг сайтар уншина уу. Та Апп-ыг хэрэглэснээр эсвэл Ашиглах нөхцөлийг зөвшөөрөх буюу хүлээн зөвшөөрөх гэсэн сонголтыг дарснаар эдгээр Ашиглах нөхцөл болон манай энд лавлагаа болон оруулсан, [эндээс орж үзэж болох](#) Нууцын Журмыг баримтлахаа зөвшөөрч байна. Хэрэв та Ашиглах нөхцөлийг зөвшөөрөхийг хүсэхгүй бол манай Апп-ыг хэрэглэж болохгүй.

Уг Апп-ыг 16 болон түүнээс дээш насны хэрэглэгчид ашиглах боломжтой. Уг Апп-ыг ашигласнаар та дараах бүх шалгуурын шаардлагыг хангаж буйгаа илэрхийлж байна. Та эдгээр бүх шаардлагыг хангахгүй байгаа бол тус Апп-ыг хэрэглэж болохгүй.

Мэдээллийн өгөгдлийг хамгаалах ерөнхий журмын хувьд Мэдээллийг өгөгдлийн хяналт болон ЕХ-ны төлөөлөгч нь баруун Дэс Мойнес мужийн QCI бөгөөд түүнтэй холбоо барих мэдээллийг доор оруулсан болно.

Эдгээр Ашиглах нөхцөлийн туршид бид “Нэрлэсэн улсууд” гэсэн нэр томъёогоор Европын Холбоо (ЕХ), Европын Эдийн Засгийн Бүс (ЕЭЗБ), болон Швейцар улсыг илэрхийлсэн болно. Хэрэв та эдгээр Нэрлэсэн улсад амьдардаг бол бид танд мэдэгдэхийг хүсэж буй хэд хэдэн эрхийг та эдэлнэ. Энэ танд хамаарах тохиолдолд эдгээр эрхийг тухайн Нэрлэсэн улсын лавлах баримтаар илэрхийлсэн байх болно.

Ашиглах нөхцөлийн өөрчлөлт

Бид зөвхөн өөрийн үзэмж шийдвэрээр эдгээр Ашиглах нөхцөлийг хааяа өөрчилж, шинэчилж болно. Бүх өөрчлөлт нь биднийг нийтэлсэн даруйд хүчин төгөлдөр болох ба тухайн мөчөөс хойших цахим хуудасны бүх хандалт, ашиглалтад хамаарна. Хэрэв бид эдгээр Ашиглалтын нөхцөлд үлэмж хэмжээний өөрчлөлт хийсэн тохиолдолд, бид танд өөрийн цахим хуудас болон

#2970591 v.2

Апп, эсвэл бусад арга хэлбэрээр танд мэдэгдэж, түүнийг хүчин төгөлдөр болохын өмнө тус өөрчлөлтийг унших боломжийг танд олгох болно.

Та шинэчилсэн Ашиглах нөхцөл нийтлэгдсэний дараа Апп-ыг үргэлжлүүлэн ашигласнаар тэдгээр өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, санал нийлж байна гэсэн үг. Өөрчлөлтийг та заавал дагаж мөрдөх ёстой тул аливаа өөрчлөлт гарсан эсэх талаар мэдээлэлтэй байх зорилгоор та хааяа энэ хуудсаар зочилж байх хэрэгтэй.

Үүрэг хариуцлага

Та эдгээр Ашиглах нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр бидэнд амлаж буй зарим амлалтыг дурдвал:

Таны хаяг

Хэрэв та манай Апп дээр хаяг үүсгэхийг сонговол та дараахыг хүлээн зөвшөөрч байна:

- Та өөрийн нууц үгийн нууцлалыг хангана.
- Та өөрийн хаягийг өөр хэн нэгэнтэй хуваалцахгүй бөгөөд эдгээр Ашиглах нөхцөл, нууцын журам зэрэг манай дүрмийг болон холбогдох хууль тогтоомжийг дагах болно.
- Та өөрийн хаягаа хаасан эсвэл урвуу ашиглалтын талаар мэдээлснээс бусад тохиолдолд таны хаягаар дамжуулан үйлдсэн бүхнийг та хариуцна.
- Уг Апп-аас гаргаж өгч буй мэдээлэл зөвхөн боловсролын зориулалттай бөгөөд оношилгоо, эмчилгээнд зориулаагүй болохыг та хүлээн зөвшөөрч байна. Энэ мэдээллийг эмчийн зөвлөснөөр ашиглах хэрэгтэй.

Мэдэгдэл ба зурвас

Манай Апп-д хандалт хийснээр та дараахыг зөвшөөрч байна:

- Та манай АПП болон үйлчилгээний талаар бид танд мэдэгдэл, зурвас илгээхийг зөвшөөрч байна. Хэрэв таны холбоо барих мэдээлэл хуучирсан бол та чухал мэдэгдлүүдээс хоцорч болзошгүй.
- Бид танд дараах арга замаар мэдэгдэл болон зурвас хүргүүлэхийг та зөвшөөрч байна: (1) Апп дотор, эсвэл (2) таны бидэнд өгсөн холбоо барих мэдээллийн дагуу илгээх замаар (тухайлбал, э-мэйл, гар утас, биет байршил хаяг). Та өөрийн холбоо барих мэдээллийг шинэчилдэг байхыг зөвшөөрч байна.
- “Healthy Birth Day” байгууллага амьгүй төрөлтөөс сэргийлж, үрсийг аврах эрхэм зорилгынхоо хүрээнд өөрийн програмчлал болон түүний үр дүнг сайжруулахын тулд таны өшиглөлт тооллогын мэдээллийг судалгааны ажил, үнэлгээ, дүгнэлтэд ашиглаж болно.

Эрх болон хязгаар

Та өөрийн мэдээллийг эзэмшинэ

Та бидэнд өгсөн өөрийн контент, санал сэтгэгдэл болон хувийн мэдээллээ өөрөө эзэмшинэ. Таны мэдээллийг бид хэрхэн ашиглах тухай таны хийсэн сонголтыг бид хүндлэх болно. Хэрэв таны аливаа мэдээлэл хувь хүний мэдээлэл орсон бол тэр нь манай Нууцын журамд хамаарахыг та болон компани харилцан зөвшөөрч байна.

Бид таны оруулсан аливаа мэдээлэл, хувийн мэдээлэлд өөрийн Нууцын журмын дагуу хандах, түүнийг хадгалах болон түүнд боловсруулалт хийж болно гэдгийг та болон компани харилцан зөвшөөрч байна.

Та хууль тогтоомж болон өөр хэн нэгний эрхийг (үүнд оюуны өмчийн эрх мөн хамаарна) зөрчөөгүй мэдээллийг л оруулахыг зөвшөөрч байна. Мөн таны оруулсан мэдээлэл үнэн зөв байхыг та зөвшөөрч байна. Компани зарим мэдээллийг хууль тогтоомжийн дагуу арилгах шаардлагатай тулгарч болзошгүй.

Бусад контент, цахим хуудас ба Апп

Манай Апп эсвэл үйлчилгээг ашигласнаар та худал, дутуу, хойшилсон, буруу ойлголт өгөх, хууль бус, доромжилсон эсвэл бусад хэлбэрээр хохирол учруулах мэдээлэлтэй таарч болзошгүй. Манай үйлчилгээ ийнхүү урвуугаар ашиглах үйлдлийг бид тэр бүр урьдчилан сэргийлж чадахгүй бөгөөд энэ тохиолдолд бид аливаа хариуцлага үүрэхгүйг та зөвшөөрч байна.

Манай цахим хуудас эсвэл үйлчилгээнээс холбосон гуравдагч этгээдийн апп эсвэл цахим хуудаст хандах эсэхийг шийдэх нь таны хариуцлага юм. Хэрэв та гуравдагч этгээдийн апп-д өөрийгөө таньж тогтоох эрхийг олговол тухайн апп эсвэл цахим хуудас танд хамаарах мэдээлэлд хандах боломжтой болж болно. Гуравдагч этгээдийн апп болон цахим хуудас нь тус тусын эрх зүйн заалтууд болон нууцын журмуудтай бөгөөд та өөрийн мэдээллийг биднээс ялгаатайгаар ашиглах зөвшөөрлийн тэдэнд өгч байж болзошгүй. Холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хязгаараас бусад тохиолдолд манай компани эдгээр бусад цахим хуудас болон апп-ын өмнөөс хариуцлага хүлээхгүй—та өөрөө эрсдэлээ үүрэн ашиглана уу. Манай Нууцын журамтай танилцана уу.

Хязгаар

Компани нь таны манай Апп эсвэл үйлчилгээг авах ашиглалтыг, тухайлбал таны холболтын тоог хязгаарлах эрхтэй. Хэрэв манай компани таныг эдгээр Ашиглах нөхцөлийг, манай Нууцын журмыг эсвэл хуулийг зөрчсөн гэж үзвэл эсвэл манай цахим хуудас болон үйлчилгээг урвуугаар ашиглаж байвал таны хаягийг хязгаарлах, түр хаах, дуусгавар болгох эрхтэй.

Оюуны өмчийн эрх

Манай компани өөрийн Апп болон үйлчилгээ дэх өөрийн бүхий л оюуны өмчийг хамгаална. Апп эсвэл үйлчилгээг ашигласнаар манай үйлчилгээ эсвэл манай Апп эсвэл үйлчилгээг дамжуулсан олсон мэдээлэл эсвэл контентыг та эзэмшинэ гэсэн үг биш юм. Манай Апп-тай холбоотой ашиглах худалдааны тэмдэг болон лого эсвэл үйлчилгээ нь өөрийн холбогдох эздийн худалдааны тэмдэг юм.

Автомат боловсруулалт

Бид таны оруулсан болон өөрийн олж авсан мэдээлэл, мэдээллийн өгөгдлийг танд хэрэгтэй байж болзошгүй холбоос, контент болон үзүүлэлтийг танд санал болгох зорилгоор ашиглах болно. Жишээлбэл бид таны тухай мэдээлэл, мэдээллийн өгөгдлийг ашиглан танд бүтээгдэхүүн санал болгож болно. Өөрийн мэдээллийг үнэн зөв, цаг үеийн байлгаснаар та бидний танд хүргэх саналыг илүү оновчтой, холбогдолтой байлгахад туслax болно.

Татгалзал ба хариуцлагын хязгаарлалт

Баталгаа гаргахгүй

ХУУЛЬ ТОГТООМЖООР ЗӨВШӨӨРӨГДСӨН ХҮРЭЭНД МАНАЙ КОМПАНИ БОЛОН ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУД (ТҮҮНЧЛЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД) (А) БАТАЛГАА БОЛОН ТӨЛӨӨЛӨЛ ГЭЖ ОЙЛГОГДОХ БҮХНЭЭС ТАТГАЛЗАЖ БАЙНА (ТУХАЙЛБАЛ, ХУДАЛДАН БОРЛУУЛЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БАТАЛГАА, ТУХАЙЛСАН ЗОРИУЛАЛТ НЬ ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХ, МЭДЭЭЛЛИЙН ӨГӨГДЛИЙН ҮНЭН ЗӨВ БОЛОН ЗӨРЧИЛГҮЙ БАЙДАЛ); (В) ҮЙЛЧИЛГЭЭ МААНЬ АЛИВАА ДОГОЛДОЛ ЭСВЭЛ АЛДААГҮЙ ХҮРНЭ ГЭСЭН БАТАЛГАА ӨГӨХГҮЙ, МӨН (С) ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ (ҮҮНД КОНТЕНТ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ХАМААРНА) “БАЙГААГААР НЬ” БОЛОН “БОЛОМЖИЙН ХЭРЭЭР” ХҮРГЭХ БОЛНО.

ЗАРИМ ХУУЛЬ ЗАРИМ ТАТГАЛЗЛЫГ ЗӨВШӨӨРДӨГҮЙ, ИЙМД ЭДГЭЭРИЙН ЗАРИМ НЬ ТАНД ХАМААРАЛГҮЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ.

Хариуцлагын хасалт

ХУУЛЬ ТОГТООМЖООР ЗӨВШӨӨРӨГДСӨН ХҮРЭЭНД (БОЛОН КОМПАНИ ХЭДИЙНЭЭ ЭНЭ ГЭРЭЭНЭЭС ИЛҮҮ ДАВУУ ҮЙЛЧЛЭЛ БҮХИЙ ТУСДАА ХЭЛЭЛЦЭЭР БИЧГЭЭР БАЙГУУЛСНААС БУСАД ТОХИОЛДОЛД), КОМПАНИ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД (ТҮҮНЧЛЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД) ТАНЫ ЭСВЭЛ ӨӨР ХЭН НЭГНИЙ ӨМНӨ ӨӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АЛИВАА ШУУД, САНААНДГҮЙ, ТУСГАЙ, УРГАН ГАРСАН ЭСВЭЛ ШИЙТГЭЛИЙН ЧАНАРТАЙ ХОХИРЛЫГ (ТУХАЙЛБАЛ, ДОРМЖИЛСОН ЭСВЭЛ ГУТААСАН МЭДЭГДЛҮҮД, АЖИЛЛАГАА ДОГОЛДОЛ, ТАНЫ МЭДЭЭЛЭЛ ЭСВЭЛ КОНТЕНТ АЛДАГДАХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЭСВЭЛ ӨӨРЧЛӨХ) ХАРИУЦАХГҮЙ.

ЯМАР Ч ТОХИОЛДОЛД КОМПАНИ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН (ТҮҮНЧЛЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД ОРНО) ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА БҮХ НЭХЭМЖЛЭЛҮҮДИЙН НИЙЛБЭР ДҮНГЭЭР (А) ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХДАА ТАНЫ ТӨЛСӨН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН САРЫН ЭСВЭЛ ЖИЛИЙН ХУРААМЖИЙГ ТАВ ДАХИН НЭМЭГДҮҮЛСЭН ДҮН, ХЭРЭВ ТӨЛБӨР ТӨЛСӨН ТОХИОЛДОЛД, ЭСВЭЛ (В) 1000 АМ.ДОЛЛАР ГЭСЭН СОНГОЛТЫН АЛЬ БАГА ҮНИЙН ДҮНГЭЭС ХЭТРЭХГҮЙ.

УГ ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ НЬ ТА БОЛОН КОМПАНИ ХООРОНД ХИЙХ ХЭЛЦЛИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОХ БА БҮХ ТӨРЛИЙН ХАРИУЦЛАГЫН НЭХЭМЖЛЭЛД (ТУХАЙЛБАЛ, БАТАЛГАА, АЛДАА, ХИЙДЭЛ, ГЭРЭЭ, ХУУЛЬ) ХАМААРАХ БА ЭНЭ НЬ КОМПАНИ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ИЙМ АЛИВАА ХОХИРЛЫН ТАЛААР УРЬДЧИЛАН МЭДЭГДСЭН БАЙСНААС БОЛОН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ НЬ ҮҮРГЭЭГ ҮНДСЭН ГҮЙЦЭТГЭЖ ЧАДААГҮЙ ЭСЭХЭЭС ҮЛ ХАМААРНА.

ЗАРИМ ХУУЛЬ ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ХАСАЛТЫГ ЗӨВШӨӨРДӨГГҮЙ, ИЙМД ЭДГЭЭР ХЯЗГААРЛАЛТ ТАНД ХАМААРАЛГҮЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ.

Дуусгавар болгох

Та болон компанийн аль аль нь эдгээр Ашиглах нөхцөлийн хүрээнд хүссэн цагтаа харилцан нэгэндээ мэдэгдэх замаар гэрээг дуусгавар болгож болно. Дуусгавар болгосноор та үйлчилгээг ашиглах, түүнд хандалт хийх эрхээ алдана. Дараах зүйл дуусгавар болгосон ч хадгалагдана:

- Таны санал сэтгэгдлийг ашиглах, нийтлэх бидний эрх;
- Эдгээр Ашиглах нөхцөлийн дараах хэсгүүд: Татгалзал ба хариуцлагын хязгаарлалт; Захиран зохицуулах хууль болон маргаан шийдвэрлэлт; болон Ерөнхий заалтууд;
- Дуусгавар болгохын өмнө харилцан нэгэндээ авлагатай байсан бол дуусгавар болгосны даруу өр хэвээр үлдэнэ.

Хэрэв та хаяг үүсгэсэн бол та манай Холбоо барих мэдээллийг ашиглан бидэнтэй холбогдож хаягаа хаалгах боломжтой.

Захиран зохицуулах хууль ба маргаан шийдвэрлэлт

Эрх зүйн маргаан гарч болзошгүй ховор тохиолдолд компани болон та Айова мужийн хууль тогтоомж ашиглан Айова мужийн шүүхэд эсвэл АНУ-ын хууль тогтоомж ашиглан АНУ-ын шүүхэд хандахыг зөвшөөрч байна.

Ерөнхий заалтууд

Эдгээр Ашиглах нөхцөлөөс дээгүүр эрх мэдэл бүхий шүүх эдгээр аль нэг заалтыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл та болон компани тэдгээр заалтыг анхны үзэл санааг хангах хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой болгон өөрчлөхийг зөвшөөрч байна. Хэрэв шүүх ингэж чадахгүй бол та болон бид шүүхэд хандан тэдгээр хэрэгжүүлэх боломжгүй хэсгийг хасан эдгээр Ашиглах нөхцөлийн үлдсэн хэсгийг хэрэгжүүлэхийг хүсэх болно гэдгийг зөвшөөрч байна.

Эдгээр Ашиглах нөхцөлийг зөрчсөн зөрчлийн мөрөөр бид арга хэмжээ авахгүй байх нь эдгээр Ашиглах нөхцөлийг сахиулах өөрийн эрхээс бид татгалзсан гэсэн үг биш. Эдгээр Ашиглах нөхцөлийн хүрээнд өөрийн эдлэх эрхийг та бидний зөвшөөрөлгүйгээр өөр хэн нэгэнд өгч, дамжуулж болохгүй. Харин, бид эдгээр Ашиглах нөхцөлийн хүрээнд эдлэх өөрийн эрхийг өөрийн харьяа байгууллагууд эсвэл тус компанийг худалдан авсан этгээдэд таны зөвшөөрөлгүйгээр өгч болно. Эдгээр Ашиглах нөхцөлд гуравдагч талын ашиг хүртэгч этгээд гэж байхгүй.

Таны зүгээс бидэнд хуулийн дагуу мэдэгдэл өгөх цорын ганц арга зам бол доорх “Холбоо барим мэдээлэл” хэсэг болохыг та зөвшөөрч байна.

Холбоо барих мэдээлэл

Эдгээр Ашиглах нөхцөлтэй холбоотой бүх асуулт, санал сэтгэгдэл болон хүсэлтийг дараах хаягаар ирүүлнэ үү:

Healthy Birth Day, Inc.
Attn: CEO
1820 N.W 118th St., Clive, IA 50325 USA
515-650-8685
info@countthekicks.org

Мэдээллийн өгөгдлийг хамгаалах ерөнхий журмын хувьд, Нэрлэсэн улсуудын оршин суугчид эдгээр Ашиглах нөхцөлтэй холбоотой бүх асуулт, санал сэтгэгдэл болон хүсэлтийг манай ЕХ-ны төлөөлөгчид хандан илэрхийлж болно:

Ascenditure, Ltd.
Attn: Count the Kicks App Developer
300 W.Arroyo St., Reno NV 89509
775-737-1988
Chris@ascenditure.co